

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/11/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2022 он	Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: А.Нарандэлгэр Утас: 70432545 цахим хаяг: narandelgera @audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
4.1 Залруулсан алдаа.....	12
4.2 Төлбөрийн акт.....	12
4.3 Албан шаардлага	12
4.4 Зөвлөмж	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХОА	Ховд аймаг
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ДАВААСҮРЭН ТАНАА

2022.02.17-№ 2/33
танай _____-ны № _____-Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймаг дахь Шүүхийн тамгын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЯДБААТАР



021020166

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,721,090	16,552,942
33	АВЛАГА	900,000	1,275,000
335	Бусад авлага	900,000	1,275,000
3351	Байгууллагаас авах авлага	900,000	1,275,000
35	БАРАА МАТЕРИАЛ	15,821,090	15,277,942
354	Хангамжийн материал	15,821,090	15,277,942
35410	Бичиг хэргийн материал	775,200	1,008,500
35420	Аж ахуйн материал	250,500	267,500
35440	Түлш, шатах тослох материал	2,180,000	00
35470	Бусад хангамжийн материал	12,615,390	14,001,942
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,429,248,586	1,454,608,300
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,429,248,586	1,454,608,300
392	Биет хөрөнгө	1,392,347,086	1,417,956,800
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,259,941,854	1,259,637,564
39202	Хуримтлагдсан элэгдэл	-51,571,758	-83,646,054
39203	Авто-тээврийн хэрэгсэл	117,182,542	179,182,542
39204	Хуримтлагдсан элэгдэл	-73,292,528	-87,756,285
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	134,650,019	150,199,678
39206	Хуримтлагдсан элэгдэл	-52,465,605	-44,784,303
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	125,047,422	125,307,422
39208	Хуримтлагдсан элэгдэл	-67,232,860	-80,507,196
39217	Ном	88,000	323,432
393	Биет бус хөрөнгө	36,901,500	36,651,500
39301	Програм хангамж	1,550,000	1,550,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	-612,500	-862,500
39303	Бусад биет бус хөрөнгө	35,964,000	35,964,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,445,969,676	1,471,161,242
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,445,969,676	1,471,161,242
51	Засгийн газрын хувь оролцоо	1,445,969,676	1,471,161,242
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	365,419,254	365,419,254
51101	Өмч: - төрийн	365,419,254	365,419,254
512	Хуримтлагдсан үр дүн	976,216,971	1,001,408,537
51210	Өмнөх үеийн үр дүн	976,216,971	976,216,971

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	104,333,452	104,333,452
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,445,969,676	1,471,161,242

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,190,676,999	1,182,925,280
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,912,299	91,744,580
120	Нийтлэг татварын бус орлого	63,975,399	91,744,580
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,965,399	89,334,580
120009	Бусад орлого	15,010,000	2,410,000
122	Тусламжийн орлого	2,936,900	00
122001	Хандив тусламж /дотоод/	2,936,900	00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,123,764,700	1,091,180,700
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,123,509,700	1,089,680,700
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,123,509,700	1,089,680,700
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	255,000	1,500,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	255,000	1,500,000
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,182,759,257	1,157,512,412
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,182,759,257	1,157,512,412
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,144,230,114	1,154,184,651
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	795,552,800	815,148,919
210101	Үндсэн цалин	610,267,262	632,584,382
210102	Нэмэгдэл	122,980,116	120,385,183
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,578,000	26,397,000
210104	Урамшуулал	36,727,422	35,782,354
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,078,428	106,581,818
210201	Тэтгэврийн даатгал	68,053,332	73,824,664
210202	Тэтгэмжийн даатгал	8,006,275	8,214,489
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,405,017	6,544,711
210204	Ажилгүйдлийн даатгал	1,601,254	1,636,177
210205	Эрүүл мэндийн даатгал	16,012,550	16,361,777
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,186,917	55,598,774
210301	Гэрэл, цахилгаан	58,253,017	47,664,874
210303	Цэвэр, бохир ус	7,933,900	7,933,900
2104	Хангамж, бараа материалын зардал	54,502,576	52,704,676
210401	Бичиг хэрэг	15,305,550	15,738,200
210402	Тээвэр, шатахуун	24,374,690	21,718,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,215,636	8,771,400
210404	Ном, хэвлэл	229,700	350,736
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000	600,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,777,000	5,526,340

2105	Нормативт зардал	882,100	1,019,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	882,100	1,019,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,334,772	18,684,770
210601	Багаж, техник, хэрэгсэл	543,600	2,857,000
210604	Урсгал засвар	40,791,172	15,827,770
2107	Томилолт, зочны зардал	8,480,350	12,512,000
210702	Дотоод албан томилолт	8,480,350	12,512,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,553,614	3,933,517
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,487,750	1,738,134
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	336,000	336,000
210803	Даатгалын үйлчилгээ	809,100	1,047,175
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,364	185,748
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	81,000	108,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	588,500	478,500
210807	Газрын төлбөр	59,900	39,960
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,658,557	88,001,176
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00	1,500,000
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	72,658,557	86,501,176
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,529,143	3,327,762
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,000,000	2,000,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,000,000	2,000,000
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,529,143	1,327,762
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,176,143	1,327,762
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,917,742	25,412,868
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00	221,302
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00	221,302
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00	-221,302
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	7,917,742	25,191,566

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	365,419,254	109,783,280	962,849,401	1,438,051,934
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00	00	5,449,828	5,449,828
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	365,419,254	109,783,280	968,299,229	1,443,501,763
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00	-5,449,828	00	-5,449,828
C07	Тайлант үеийн үр дүн	00	00	7,917,742	7,917,742
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	365,419,254	104,333,452	976,216,971	1,445,969,676
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	365,419,254	104,333,452	976,216,971	1,445,969,676
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	365,419,254	104,333,452	976,216,971	1,446,273,966

D08	Тайлант үеийн үр дүн	00	00	25,191,566	25,191,566
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	365,419,254	104,333,452	1,001,408,237	1,471,161,242

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,123,862,700	1,091,180,700
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,123,862,700	1,091,180,700
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,123,509,700	1,089,680,700
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,123,509,700	1,089,680,700
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	353,000	1,500,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	353,000	1,500,000
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,110,122,800	1,070,366,200
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,110,122,800	1,070,366,200
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,071,593,657	1,067,038,438
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	795,552,800	815,148,919
210101	Үндсэн цалин	610,227,262	632,584,382
210102	Нэмэгдэл	122,980,116	120,385,183
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,578,000	26,397,000
210104	Урамшуулал	36,767,422	35,782,354
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,078,428	106,581,818
210201	Тэтгэврийн даатгал	68,053,332	73,824,664
210202	Тэтгэмжийн даатгал	8,006,275	8,214,489
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,405,017	6,544,711
210204	Ажилгүйдлийн даатгал	1,601,254	1,636,177
210205	Эрүүл мэндийн даатгал	16,012,550	16,361,777
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,186,917	55,598,774
210301	Гэрэл, цахилгаан	58,253,017	47,664,874
210303	Цэвэр, бохир ус	7,933,900	7,933,900
2104	Хангамж, бараа материалын зардал	54,609,476	50,970,940
210401	Бичиг хэрэг	14,357,550	15,971,500
210402	Тээвэр, шатахуун	26,253,990	19,538,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,215,636	8,861,500
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000	600,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,182,300	5,999,940
2105	Нормативт зардал	800,000	800,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000	800,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,420,572	19,848,470
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,473,400	3,784,500
210604	Урсгал засвар	39,947,172	16,063,970
2107	Томилолт, зочны зардал	8,480,350	12,512,000

210702	Дотоод албан томилолт	8,480,350	12,512,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,465,114	4,077,517
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,987,750	2,113,134
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	336,000	336,000
210803	Даатгалын үйлчилгээ	809,100	1,047,175
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,364	185,748
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	81,000	108,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00	247,500
210807	Газрын төлбөр	59,900	39,960
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00	1,500,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00	1,500,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,529,143	3,327,762
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,000,000	2,000,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,000,000	2,000,000
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,529,143	1,327,762
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,176,143	1,327,762
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13,739,900	20,814,500
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00	00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,739,900	20,814,500
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,739,900	20,814,500
2200	Дотоод эх үүсвэрээр	13,739,900	20,814,500
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,739,900	20,814,500
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-13,739,900	-20,814,500
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00	00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00	00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00	00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00	00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00	00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,089,680,700	1,088,352,938
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,089,680,700	1,088,352,938
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,087,680,700	1,086,352,938
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	815,150,000	815,148,919
210101	Үндсэн цалин	663,196,100	632,584,382
210102	Нэмэгдэл	110,990,000	120,385,183

210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,884,400	26,397,000
210104	Урамшуулал	15,079,500	35,782,354
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,188,200	106,581,818
210201	Тэтгэврийн даатгал	75,628,700	73,824,664
210202	Тэтгэмжийн даатгал	7,889,900	8,214,489
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,311,900	6,544,711
210204	Ажилгүйдлийн даатгал	1,578,000	1,636,177
210205	Эрүүл мэндийн даатгал	15,779,700	16,361,777
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,113,700	55,598,774
210301	Гэрэл, цахилгаан	48,179,800	47,664,874
210303	Цэвэр, бохир ус	7,933,900	7,933,900
2104	Хангамж, бараа материалын зардал	50,971,000	50,970,940
210401	Бичиг хэрэг	15,971,500	15,971,500
210402	Тээвэр, шатахуун	19,538,000	19,538,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,861,500	8,861,500
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000	600,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000,000	5,999,940
2105	Нормативт зардал	800,000	800,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000	800,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,664,000	40,662,970
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,600,000	24,599,000
210604	Урсгал засвар	16,064,000	16,063,970
2107	Томилолт, зочны зардал	12,512,000	12,512,000
210702	Дотоод албан томилолт	12,512,000	12,512,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,281,800	4,077,517
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,232,700	2,113,134
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000	336,000
210803	Даатгалын үйлчилгээ	1,048,300	1,047,175
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,300	185,748
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000	108,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	280,500	247,500
210807	Газрын төлбөр	60,000	39,960
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000	2,000,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000	2,000,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000	2,000,000
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,091,180,700	1,088,352,938
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,089,680,700	1,088,352,938
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,089,680,700	1,088,352,938
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42	39
620001	Удирдах ажилтан	05	05
620002	Гүйцэтгэх ажилтан	30	28
620003	Үйлчлэх ажилтан	07	06
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	42	39
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	16	16

650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	13	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13	12

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор А.Нарандэлгэр 2022 оны 01 дүгээр сарын 24-нээс 2021 оны 02 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 05/30 дугаарын албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газар нь 2021 онд “Монгол улсын үндсэн хууль, шүүхийн тухай хууль, шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу шүүх, шүүгчийн аюулгүй байдал, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүн таслах ажиллагаа болон шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах, шүүхийн нээлттэй ил тод байдлыг хангах” зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газар тус байгууллагад Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын алба 2021 онд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны батлагдсан төсвийн 1,089.7 сая төгрөгөөс 2.0 хувиар тооцон 21.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 17.4 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25.2 сая төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Тайлант онд авлага 0.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа болон түдгэлзүүлсэн хэргүүдтэй холбоотой бөгөөд хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гарсны дараа барагдах 1.3 сая төгрөгийн авлагыг үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 15.3 сая төгрөг болж 0.5 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 63.3 сая төгрөг, шилжүүлэн авсан 0.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 64.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1,429.2 мянган төгрөг, оны эцэст 1,454.6 сая төгрөг болж 20.4 сая төгрөгөөр өссөн нь ШЕЗ-өөс суудлын авто машин, ширээний компьютер, сканер, хяналтын камер, ном зэрэг хөрөнгүүд бэлтгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд 20.8 сая төгрөгийн хөрөнгө төсвөөс бэлтгэж, 88.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 2.4 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж бүртгэсэн, 34.3 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 1,445.9 сая төгрөг байсан оны эцэст 1,471.2 сая төгрөг болж тайлант онд 25.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1001.4 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,530.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 1,089.7 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1,089.7 сая төгрөгийн төсөв батлагдаж, 1089.7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,088.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,088.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,088.4 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 0.6 сая төгрөгөөр, Байр ашиглалттай тогтмол зардлыг 0.5 сая төгрөгөөр, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлыг 0.2 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 1.5 сая төгрөгийн орлого Аймгийн ИТХ-аас төвлөрүүлж, 1.5 сая төгрөгийн зардлыг шагнал урамшууллын зардалд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг 82.4 хувьтай мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.2 сая төгрөгийн алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1.4 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Хөрөнгө актлахдаа дансны бичилт буруу хийж, хуримтлагдсан элэгдэл, тайлант оны элэгдлийн зардал, дахин үнэлгээний нэмэгдэл дансыг зөрүүтэй тайлагнасан 1.2 сая төгрөг,

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт1: Аудитаар шатахууны зардлыг хянахад амралт, баяр ёслолын өдрүүдэд 1.4 сая төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Энэ нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, Өршөөлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг мөрдөн ажиллаж шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах .

Илрүүлэлт2: Аудитаар Бэлтгэн нийлүүлэгчээс бараа материал худалдан авахдаа төлбөрийн баримтаар бүрэн гүйцэд баталгаажуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалыг мөрдөн ажиллаж төлбөрийн баримтаар бүрэн гүйцэд баталгаажуулан ажиллах .


Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газар	3	2.6	1	1.2	-	-	-	-	2	1.4

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР:  А.НАРАНДЭЛГЭР



